



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН ЗАХИРАМЖ

2013 оны 3 дугаар
сарын 28-ны өдөр

Дугаар 52

Улаанбаатар
хот

Ажлын хэсэг шинэчлэн батлах тухай

1. Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн өөрчлөгдсөнтэй холбогдуулан Монгол Улс, Оросын Холбооны Улсын Засгийн газар хооронд байгуулах Төмөр замаар ачаа тээвэрлэх тарифын хэлэлцээрийн төслийг боловсруулах талаар Оросын талтай хэлэлцээ хийх үүрэг бүхий монголын талын Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг дор дурдсанаар шинэчлэн баталсугай:

Ахлагч

-Зам, тээврийн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ё.Манлайбаяр

Гишүүд:

- Засгийн газрын референт Б.Оргил;
- Эдийн засгийн хөгжлийн яамны Эдийн засгийн хамтын ажиллагаа, зээл, тусламжийн бодлогын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Болдбаатар;
- Гадаад харилцааны яамны Гэрээ, эрх зүйн газрын дэд захирал А.Төмөр;
- Сангийн яамны Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн хэлтсийн дарга М.Батгэрэл;
- Гадаад харилцааны яамны Хөрш орнуудын газрын зөвлөх Б.Энхбаяр;
- Хууль зүйн яамны Хууль зүйн нэгдсэн бодлогын газрын мэргэжилтэн Ч.Бат-Эрдэнэ;
- Зам, тээврийн яамны Төмөр замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтсийн мэргэжилтэн С.Халиун;
- “Улаанбаатар төмөр зам” хувь нийлүүлсэн нийгэмлэгийн Тээвэр хариуцсан орлогч дарга Ш.Эрдэнэбулган;
- “Улаанбаатар төмөр зам” хувь нийлүүлсэн нийгэмлэгийн Тарифын хэлтсийн дарга Б.Солонго.

Нарийн бичгийн
дарга

-Зам, тээврийн яамны Төмөр замын бодлогын
хэрэгжилтийг зохицуулах хэлтсийн мэргэжилтэн
Б.Зоригтбаатар.

2. Оросын талтай хэлэлцээ хийж, явц болон дүнг тухай бүр Засгийн газарт танилцуулж байхыг Ажлын хэсэг (Ё.Манлайбаяр)-т даалгасугай.

3. Энэ захирамж гарсантай холбогдуулан "Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг шинэчлэх батлах тухай" Ерөнхий сайдын 2011 оны 4 дүгээр сарын 6-ны өдрийн 28 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

Н.АЛТАНХУЯГ